ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2024/16/НА-СТА-ТТ3**

Цахим хуудас: www.open.audit.mn

Чингис хот

2024 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.25 № 391

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ц.БАТЦООЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 675,926.1 мянган төгрөг, авлага 231,088.7 мянган төгрөг, урьдчилгаа 9,000.0 мянган төгрөг, бараа материал 103,254.5 мянган төгрөг, нөөцийн бараа 15,400.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,205,375.3 мянган төгрөг, өр төлбөр 324.9 мянган төгрөг, засгийн газрын сан 293,627.3 мянган төгрөг, хуримтлагдсан үр дүн 3,806.510.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 730,625.9 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 550,487.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,265,582.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 318,450.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Тус сумын харьяа байгууллагуудад нийт 26,062.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11,168.2 мянган төгрөгийн 2 алдаа, 14,494.4 мянган төгрөгийн 10

232420481

зөрчил байна. Зөрчлийн 6,979.6 мянган төгрөг буюу 48.1 хувь нь нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой зөрчил эзэлж байна. Иймд байгууллагуудын нягтлан бодогч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, нягтлан бодогчийн сул орон тоог нөхөх зэрэг арга хэмжээ авч ажиллан бүртгэл, хөтлөлттэй холбоотой зөрчлийг таслан зогсоох шаардлагатай байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын Засаг дарга нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлээгүй тул дараа жилийн аудитад анхаарах шаардлагатай.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаарахгүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

| Дансны код | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 637,902.40 | 1,034,669.30 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 341,518.84 | 675,926.06 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 201,229.33 | 231,088.74 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7а, 7б | - | 9,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 89,754.24 | 103,254.51 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 5,400.00 | 15,400.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,047,721.82 | 3,205,375.31 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 3,047,721.82 | 3,205,375.31 |
| 39200 | Биет хөрөнгө | | 3,003,567.82 | 3,161,251.31 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 44,154.00 | 44,124.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 3,685,624.22 | 4,240,044.62 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 206.35 | 324.94 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 206.35 | 324.94 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 206.35 | 324.94 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 3,685,417.87 | 4,239,719.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 3,685,417.87 | 4,239,719.68 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 293,627.26 | 293,627.26 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 3,188,643.00 | 3,806,510.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 203,147.61 | 139,582.29 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | - | 3,685,624.22 | 4,240,044.62 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 4,061,019.97 | 3,357,988.73 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 333,591.01 | 532,101.35 |
| 110 | Орлогын албан татвар | | 110,056.48 | 127,134.99 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 110,056.48 | 127,134.99 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 62,017.57 | 59,059.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 161,516.96 | 345,906.66 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 2,133,228.40 | 356,061.25 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 2,133,228.40 | 356,061.25 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,594,200.56 | 2,469,826.13 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 3,327,742.54 | 2,572,166.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,770,562.55 | 2,572,166.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 785,067.94 | 983,324.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 312,921.85 | 422,083.85 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 39,892.64 | 53,072.35 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 162,285.15 | 31,548.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 26,811.87 | 27,935.26 |
| 2105 | Нормативт зардал | | 419.00 | 855.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 24,191.98 | 5,869.80 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 12,162.90 | 17,224.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 41,818.02 | 241,889.34 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 164,564.53 | 182,845.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 985,494.61 | 1,588,842.03 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | | 733,277.43 | 785,822.63 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 314,217.26 | 233,446.70 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | | 419,060.17 | 552,375.93 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхий хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгийн дүн |
|---|---|---|---|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,352,477.61 | - | 3,352,477.61 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (86,119.91) | - | (86,119.91) |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,266,357.70 | - | 3,266,357.70 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 419,060.17 | - | 419,060.17 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,685,417.87 | - | 3,685,417.87 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,685,417.87 | - | 3,685,417.87 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 65,491.20 | - | 65,491.20 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,750,909.07 | - | 3,750,909.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | (63,565.32) | - | (63,565.32) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 552,375.93 | - | 552,375.93 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,239,719.68 | - | 4,239,719.68 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2,004,432.97 | 3,057,949.83 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 333,591.01 | 532,101.35 |
| 110 | Орлогын албан татвар | 110,056.48 | 127,134.99 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 110,056.48 | 127,134.99 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 62,017.57 | 59,059.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 161,516.96 | 345,906.66 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 18,976.23 | 27,665.98 |
| 1181 | Газрын төлбөр | 9,303.34 | 48,349.77 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 133,237.39 | 269,890.91 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 71,504.78 | 55,332.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 71,504.78 | 55,332.87 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,599,337.18 | 2,470,515.60 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,712,121.91 | 2,465,815.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,712,121.91 | 2,465,815.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 690,188.61 | 875,973.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 312,715.83 | 421,982.62 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,877.50 | 53,259.67 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 161,815.55 | 30,938.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,526.17 | 27,720.45 |
| 2105 | Нормативт зардал | 697.00 | 347.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,539.98 | 5,282.70 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,162.90 | 17,202.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,487.02 | 262,637.77 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,366.66 | 56,603.55 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,021,933.30 | 1,589,842.03 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 292,311.06 | 592,133.84 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 158,455.90 | 197,726.62 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 158,455.90 | 197,726.62 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 158,455.90 | 197,726.62 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (158,455.90) | (197,726.62) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 133,855.16 | 334,407.22 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 207,663.68 | 341,518.84 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 341,518.84 | 675,926.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,639,963.90 | 1,132,303.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,220,213.10 | 895,678.19 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,181,400.90 | 892,468.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 515,984.30 | 421,982.62 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,499.40 | 53,259.67 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 295,591.90 | 177,653.94 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,284.80 | 27,254.73 |
| 2105 | Нормативт зардал | 1,588.60 | 347.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,764.40 | 49,067.44 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,796.10 | 17,202.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 143,052.20 | 89,697.04 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,839.20 | 56,003.55 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 38,812.20 | 3,210.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 38,812.20 | 3,210.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 266,150.80 | 176,625.62 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 153,600.00 | 60,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,639,963.90 | 1,130,229.26 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,429,179.90 | 1,097,282.89 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 165,611.40 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 137,390.93 | 163,536.85 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,704.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,704.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,606.77 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,381.57 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 465.72 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 258.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,901.48 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,098.22 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,704.99 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,704.99 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1], зөрчил[2] илрээгүй байна.

Засаг даргын тайланд нэгтгэгдсэн орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,564.6 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 8,405.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 4,158.8 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч ажилласан.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 8,405.8 | | | 1 | 8,405.8 | 1 | 8,405.8 | | | | |
| **Дүн** | **1** | **8,405.8** | | | **1** | **8,405.8** | **1** | **8,405.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/т | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 4,158.8 | | | | | 1 | 4,158.8 | | | | |
| **Дүн** | **1** | **4,158.8** | | | | | **1** | **4,158.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | | | | | | | | |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | - | - | - | - | - | - | - | - |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.